



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 678

Улаанбаатар хот

□ Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай □

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 36 дугаар зүйлийн 36.1.1, 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.3, 41 дүгээр зүйлийн 41.1.1, 41.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Сэлэнгэ эстимэйт” ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа явуулахгүй байх үүргийг “Сэлэнгэ эстимэйт” ХХК (Д.Дэлгэрсүрэн)-д даалгасугай.

3.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авахыг “Сэлэнгэ эстимэйт” ХХК (Д.Дэлгэрсүрэн)-д анхааруулсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН